



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/556

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.6, аймгийн нийгэм эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6 сумын нутагт шинээр гаргасан 6 инженерийн хийцтэй худгийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Н.Эрдэнэ-Очир(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)  
Нарийн бичгийн дарга: Ж.Шинэ-Уянга(Хүнс,хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)  
Гишүүд: Б.Мөнхжаргал(Хүнс,хөдөө аж ахуйн газрын дарга)  
Б.Цэрэнсугир(Байгаль, орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)  
Б.Дэлгэржаргал(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)  
Д.Болд(Ус инженеринг ХХК-ны захирал)  
Холбогдох сумын Засаг дарга

Хоёр. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр гаргасан инженерийн хийцтэй худгийг худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах, ажилд тавих техникийн шаардлага MNS 6088:2010 стандарт, техникийн тодорхойлолтонд заасан баримт материалын дагуу хүлээн авахыг Ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010705